

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 02 дугаар  
сарын 13-ний өдөр

Улаанбаатар  
хот

Дугаар53

## ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хэвлэлийн үйлдвэрлэл” хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт ёсоор, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах, төслүүдийг сонирхогч орон, олон улсын байгууллагад санал болгох арга хэмжээ авч ажиллахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Сангийн сайд Ч.Улаан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа нарт даалгасугай.

3.Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажиллан биелэлтийг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд даалгасугай.

Гарын үсэг

## **“ХЭВЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ” ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарын өнөөгийн байдал**

1. Өнөөгийн байдлаар Улаанбаатар хотод 200 гаруй, орон нутагт 20 гаруй аж ахуйн нэгж хэвлэлийн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Статистикийн мэдээгээр 2006 оны байдлаар хэвлэл, цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 1 хувийг эзэлж байна. Дотоодын хэвлэлийн бүтээгдэхүүний хэрэглээний 40 орчим хувь буюу жилдээ 20 гаруй тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн гадаадад захиалгаар хэвлэгдэж, цаашид улам өсөх хандлагатай байна. Хэвлэлийн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүхий эд материал нь гадаадаас шууд хамааралтай байдаг.

2. Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарт 4000 орчим хүн ажиллаж, хүний нөөцийн чадавхи, сургалтын тогтолцоог сайжруулах нь тулгамдсан асуудлын нэг болоод байна. Орон нутагт хэвлэлийн үйлдвэрлэлийг дэмжих бодлого байхгүй, мэргэжлийн боловсон хүчний хангамж дутагдалтай, дэд бүтцийн хөгжил сул байна. Улаанбаатар хотод төвлөрч байгаа хэвлэлийн үйлдвэрүүдийг хэвийн ажиллах нөхцлөөр хангах, эдийн засаг, санхүүгийн чадавхитай болгох арга хэмжээ үгүйлэгдэж байгаа юм.

### **Хоёр. Хөтөлбөр боловсруулах үндэслэл**

3. Дотоодын хэвлэлийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд хэвлэлийн үндсэн, туслах материал болон дэвшилтэт техник, тоног төхөөрөмжүүдийг нэвтрүүлэх нь чухал байна. Хэвлэлийн үйлдвэрлэлд дэлхийн хөгжлийн хандлага болсон тоон хэвлэлийн технологид суурилсан “хэрэгцээ дагасан хэвлэлт”-ийн технологийг нэвтрүүлэх шаардлага гарч байна. Сүүлийн жилүүдэд хэвлэмэл бүтээгдэхүүний дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээ эрчимтэй өсч байгаатай холбогдуулан үндэсний хэвлэлийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин хөгжүүлэх зайлшгүй шаардлага тавигдаж байна.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл ажиллагаа**

4. Хөтөлбөрийн зорилго нь хэвлэлийн үйлдвэрлэл эрхлэх тааламжтай нөхцлийг бүрдүүлж үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтээгдэхүүний нэр төрөл, чанарыг нэмэгдүүлэхэд оршино.

5. Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтоор хэрэгжүүлнэ:

5.1. Хэвлэлийн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, зохицуулах эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх;

5.2. Хэвлэлийн үйлдвэрлэлд импортын бүтээгдэхүүн, түүхий эдийг орлуулах дотоод үйлдвэрлэлийг өргөжүүлэх.

5.3. Шинэ дэвшилтэт техник, технологи, шинжлэх ухаан, техникийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартад нийцүүлэх;

5.4. Орон нутагт хэвлэлийн үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх;

5.5. Хэвлэлийн салбарын хүний нөөцийн чадавхийг сайжруулах.

6. Хөтөлбөрийн 5.1 дэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

6.1. Хэвлэлийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж боловсруулах;

6.2. Үйлдвэрлэлийн болон бүтээгдэхүүний стандарт, техникийн нөхцлийг боловсруулах, шинэчлэн батлуулах;

6.3. Хэвлэлийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төсвийн хөрөнгөөр бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаанд салбарын мэргэжлийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх.

7. Хөтөлбөрийн 5.2 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

7.1. Дотоодын түүхий эдэд тулгуурласан цаасны үйлдвэр байгуулах судалгаа хийж техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах;

7.2. Хэвлэлийн будаг, бодис болон бусад туслах материалын үйлдвэрлэл байгуулах төслийг хөнгөлөлттэй зээлд хамруулах;

7.3. Байгаль орчинд халгүй, дэлхийн жишигт нийцсэн сав, баглаа боодол, шошгоны үйлдвэрийг байгуулахад техникийн тусламж авах;

7.4. Бага оврын хэвлэлийн техник, сэлбэг хэрэгслийн үйлдвэрийг орон нутгийн бүсийн төвд байгуулах.

8. Хөтөлбөрийн 5.3 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

8.1. Хэвлэлийн техник, технологи, машин, тоног төхөөрөмжийг лизингээр олгох нөхцлийг бүрдүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх;

8.2. Хэвлэлийн үйлдвэрийн технологийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх;

8.3. Хэвлэлийн судалгаа, шинжилгээ хийх, чанарын хяналтын лаборатори байгуулах;

8.4. Техникийн засвар үйлчилгээний сүлжээ бий болгох.

8.5. Дэлхийн дэвшилтэт технологийг нутагшуулахад төсөлд шаардагдах хөрөнгө оруулалтын эх үүсвэр хайж, хөнгөлөлттэй зээлд хамруулах;

8.6. Хэвлэлийн үйлдвэрлэлийн парк, кластерын судалгаа хийж байгуулах урьдчилсан нөхцлийг бүрдүүлэх.

9. Хөтөлбөрийн 5.4 дэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

9.1. Ном, хэвлэлийн бүтээгдэхүүн, түүхий эд материалыг орон нутагт хүргэх, түгээх сүлжээг байгуулах;

9.2. Хэвлэлийн үйлдвэрлэл орон нутагт хэвлэлийн үйлдвэрлэл байгуулах, технологийн шинэчлэл хийх төслийг хөнгөлөлттэй зээлд хамруулах;

10. Хөтөлбөрийн 5.5 дахь зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

10.1. Хэвлэлийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлэх;

10.2. Салбарын ажил мэргэжлийн ангилал, мэргэжлийн үндсэн норматив, хөдөлмөрийн тарифыг шинэчлэн боловсруулах;

10.3. Хэвлэлийн үйлдвэрийн удирдлага, мэргэжлийн ажилтан бэлтгэх зориулалттай сургалт, үйлдвэр түшиглэсэн дадлагын төвийг байгуулж ажиллах.

11. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн зарчим нь хэвлэлийн үйлдвэр, цех, бизнес эрхлэгчид болон мэргэжлийн холбоод, төрийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа, идэвхтэй оролцоонд тулгуурлах явдал юм.

### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат**

12. Хөтөлбөрийг 2008 - 2016 онд дараахь үе шатаар хэрэгжүүлнэ:

12.1. Нэгдүгээр үе шат: 2008 - 2010 онд а/үйлдвэрлэл хөгжүүлэх эрх зүйн орчин болон стандартыг шинэчлэн бүрдүүлэх; б/үйлдвэрлэлийн тулгамдсан асуудлыг судлан шийдвэрлэж, техник, технологийн шинэчлэлийг эхлүүлэх; в/дотоодын зах зээлд салбарын эзлэх байр суурийг нэмэгдүүлэх,

12.2. Хоёрдугаар үе шат: 2011 - 2016 онд а/үйлдвэрлэх бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, салбарын дотоод зах зээлд эзлэх байр суурийг өсгөн бататгах;

б/орчин үеийн дэвшилтэт шинэ техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;

в/салбарын үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэгдсэн бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

### **Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт**

13. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг Үйлдвэр, худалдааны яам, Монголын хэвлэлийн үйлдвэрүүдийн мэргэжлийн холбоо болон хувийн хэвшлийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

14. Үйлдвэр, худалдааны яам хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох яам, байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодоос жил бүрийн 2, 4 дүгээр улиралд авч нэгтгэн тайлагнаж байна.

### **Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт**

15. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дор дурдсан санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

15.1. аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт;

15.2. жижиг, дунд үйлдвэрийг дэмжих болон хөрөнгө оруулалт, хөгжлийн сан

15.3. олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл;

15.4. дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалт;

15.5. банкны зээл;

15.6. улсын болон орон нутгийн төсөв.

### **Долоо. Шалгуур үзүүлэлт**

16. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр хэмжинэ:

16.1. Эрх зүйн орчин болон стандартын байдалд хөндлөнгийн шинжээчийн хийсэн үнэлгээ дүгнэлт;

16.2. Хэвлэлийн бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтүүд;

16.3. Шинэ техник, технологи, инноваци нэвтэрсэн байдал;

16.4. Ажлын байрны өсөлт, ажиллагсдын мэргэжил, мэдлэгийн өсөлт, зорилтот сургалтын тоо, түүнд хамрагдсан хүний тоо.

--- оОо----

**ХЭВЛЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шаардлагатай хөрөнгө /сая.төг/									Эх үүсвэр	Хэрэгжилтийг зохицуулах, хамтран ажиллах байгууллага	
			2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016			
Хэвлэлийн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, зохицуулах эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх	Япон, ХБНГУ, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй орны хэвлэлийн үйлдвэрлэлийн стандартыг орчуулан үндэсний стандарт бий болгох, шаардлагатай үндэсний стандартуудыг боловсруулах	2008-2016	5.0	5.0			2.0				2.0		Улсын төсөв	ҮХЯ СХҮТ МХҮХ
	Хэвлэлийн үйлдвэрлэлд шаардлагатай тоног, төхөөрөмжийг тодорхой хугацаанд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх	2008-2012												
Дотоодын түүхий эдэд тулгуурласан цаасны үйлдвэр байгуулах судалгаа хийж техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах	Дотоодын түүхий эдэд тулгуурласан цаасны үйлдвэр байгуулах судалгаа тооцоо хийх	2009	100.0										Улсын төсөв	ҮХЯ МХҮХ
	Цаасны үйлдвэр байгуулахад хөнгөлттэй зээлд хамруулах	2009-2011	300.0	300.0	300.0								Хөнгөлт-тэй зээл	ҮХЯ СЯ МХҮХ
Хэвлэлийн будаг, бодис болон бусад туслах материалын үйлдвэрлэл байгуулах төслийг хөнгөлөлттэй зээлд хамруулах	Хэвлэлийн будаг найруулах үйлдвэр байгуулах	2009-2010	100.0	150.0									Хөнгөлт-тэй зээл	ҮХЯ СЯ МХҮХ
	Бусад туслах материалын үйлдвэр байгуулах	2009-2010		150.0	170.0	170.0							Хөнгөлт-тэй зээл	ҮХЯ, СЯ МХҮХҮХЯ МХҮХ

Байгаль орчинд халгүй, дэлхийн жишигт нийцсэн сав, баглаа боодол, шошгоны үйлдвэрлэлийг байгуулахад техникийн тусламж авах	Цаасан хайрцаг, баглаа боодлын үйлдвэр байгуулах	2008-2009	100.0	500.0							Хөнгөлт-тэй зээл	ҮХЯ СЯ МХҮХ
	Шошгоны үйлдвэр байгуулах	2009-2010		300.0	700.0						Хөнгөлт-тэй зээл	ҮХЯ СЯ МХҮХ
	Цаасан уутны үйлдвэр байгуулах	2010-2011			100.0	500.0					Хөнгөлт-тэй зээл	ҮХЯ СЯ МХҮХ
Бага оврын хэвлэлийн техник, сэлбэг хэрэгслийн үйлдвэрлэлийг орон нутгийн бүсийн төвд байгуулах	Үдэх, горив гаргах зэрэг хэвлэлийн туслах тоног төхөөрөмжийн үйлдвэр байгуулахад хөнгөлөлттэй зээл олгоход дэмжлэг үзүүлэх	2008-2011	20.0	200.0	300.0	300.0					Хөнгөлт-тэй зээл	ҮХЯ СЯ МХҮХ
Хэвлэлийн техник, технологи, машин, тоног төхөөрөмжийг лизингээр олгох механизмыг бүрдүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх	Салбарын мэргэжлийн холбооны дэргэд лизингийн компани байгуулах	2008										ҮХЯ СЯ МХҮХ
	Тоног төхөөрөмжийг лизингээр олгоход салбарын мэргэжлийн холбоо арилжааны банкттай хамтран ажиллах	2008-2010										ҮХЯ СЯ МХҮХ Арилжааны банкууд
Хэвлэлийн үйлдвэрийн технологийн түвшинг дээшлүүлэх чиглэлээр шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх	Хэвлэлийн үйлдвэрлэлийн импортын хараат байдлыг багасгах техник технологийн шийдлүүдийн судалгаа	2008-2016	10.0	10.0	10.0			10.0	10.0	10.0	Улсын төсөв ШҮТ-ийн сан	ҮХЯ БСШУЯ ШҮТ-ийн сан МХҮХ
	Хэвлэлийн үйлдвэрлэлийн зарим дэвшилтэт төрлийг бий болгох зэхэц ажил хэрэгжүүлэх	2008-2016			20.0	20.0				20.0	20.0	Улсын төсөв ШҮТ-ийн сан
Хэвлэлийн судалгаа, шинжилгээ хийх, чанарын хяналтыг сайжруулах лаборатори байгуулах	Салбарын эрдэм шинжилгээний лаборатори байгуулах асуудлыг олон улсын зээл, тусламжийн хүрээнд шийдвэрлэх	2008-2009	150.0	150.0							Олон улсын тусламж	ҮХЯ СЯ
Техникийн засвар үйлчилгээний сүлжээ бий болгох	Үйлдвэр дундын засвар үйлчилгээний компани зохион байгуулах	2008-2009	100.0	100.0							Хөнгөлт-тэй зээл	МХҮХ

Дэлхийн дэвшилтэт технологийг нутагшуулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, хөнгөлөлттэй зээлд хамруулах	Тоон хэвлэл	2008-2009	700.0	150.0							Хөнгөлт-тэй зээл	ҮХЯ СЯ МХҮХ
	Торгон хэвлэл	2009-2010		500.0	200.0						Хөнгөлт-тэй зээл	ҮХЯ СЯ МХҮХ
	Флексографийн үйлдвэр	2010-2011			500.0	500.0					Хөнгөлт-тэй зээл	ҮХЯ СЯ МХҮХ
	Үнэт цаасны хэвлэл	2011-2012				900.0					Хөнгөлт-тэй зээл	ҮХЯ СЯ МХҮХ
Ном, хэвлэлийн бүтээгдэхүүн, түүхий эд материалыг орон нутагт хүргэх, түгээх сүлжээг байгуулах	Орон нутгийн хэрэглэгчдэд ном, хэвлэлийг хүргэх худалдааны тогтолцоо бий болгох	2008-2009										ҮХЯ БСШУЯ Аймгийн ЗДТГазар МХҮХ
	Хэвлэлийн түүхий эдийг орон нутгийн үйлдвэрүүдэд түгээх сүлжээ бий болгох	2008-2009										ҮХЯ МХҮХ
Салбарын ажил мэргэжлийн ангиллыг шинэчлэн батлах, хөдөлмөрийн тариф мэргэжлийн үндсэн нормативыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх	Салбарын ажил мэргэжлийн ангиллыг шинэчлэн батлах, хөдөлмөрийн тариф мэргэжлийн үндсэн нормативыг шинэчлэн батлуулах	2008										НХХЯ ҮХЯ МХҮХ
	Гурван талт хэлэлцээр байгуулах	2008-2009										НХХЯ ҮХЯ МХҮХ
Нарийн мэргэжлийн ажилтан бэлтгэх зохион байгуулалтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх		2008-2009										БСШУЯ, ҮХЯ Их дээд сургуулиуд МХҮХ
Хэвлэлийн үйлдвэрийн менежментийг боловсронгуй болгох, бизнес эрхлэх дэвшилтэт аргыг эзэмшүүлэх, мэргэжлийн ажилтан бэлтгэх зориулалттай	Салбарын сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг бизнес инкубаторыг түшиглүүлэн байгуулах	2008-2009	50.0	50.0							Улсын төсөв	ҮХЯ БСШУЯ МХҮХ
	Гадаадын өндөр хөгжилтэй орнуудад мэргэжилтэн бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах	2008-2016	20.0	20.0		20.0	20.0			20.0	20.0	Улсын төсөв

сургал, дадлагын төвүүдийг байгуулах	Гадаадын ижил төстэй байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх	2008-2016												ҮХЯ, ГХЯ, МХҮХ
ДҮН	Улсын төсөв		185.0	135.0	30.0	40.0	22.0	-	10.0	52.0	50			
	Хөнгөлттэй зээл		1320.0	2350.0	2670.0	3070.0	700.0	-	-	-	-			
	Олон улсын тус-ламж		150.0	-	-	-	-	-	-	-	-			

---- о О о ----